

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан	2
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	7
2.13	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3.	<i>Менежментийн захидал</i>	8
3.1	Өглөгийн данстай холбоотой асуудал.....	8
3.2	Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар.....	8
3.3	Шилэн данстай холбоотой асуудал.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Нэмэлт санхүүжилтийн тайлан	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын баримт бичиг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
КОМИССЫН ГИШҮҮН П.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

2020.04.24 № 1317
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

A red rectangular official stamp is placed over a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp contains some faint, illegible text and a central emblem.

Д.ЗАНДАНБАТ

Комиссын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, комиссын гишүүн П.Оюунчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах, шилэн дансны сайтад мэдээллийг хугацаанд нь байршуулах, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комиссын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 5-наас 2020 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа нар гүйцэтгэв.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 4/210 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүний эрхийн Үндэсний Комисс дараах асуудлын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улс дахь хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах;
- Хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал өгөх;
- Олон улсын хүний эрхийн гэрээний биелэлт, энэ тухай Засгийн газрын илтгэлийг боловсруулахад санал өгөх;
- Комиссын гишүүн Улсын Их Хурлын чуулган, Засгийн газрын хуралдаанаар хүний эрхтэй холбогдсон асуудал хэлэлцэхэд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын хүсэлтээр зөвлөх эрхтэй оролцох, хүний эрхийн асуудлаар судалгаа хийх зорилгоор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэргийн материалтай танилцах, холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлах эрх бүхий албан тушаалтан, байгууллагад уламжлах.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа НБББББ-ийг 2014 онд боловсруулж баталснаас хойш төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинэчлэн гаргасан дүрэм журам болон холбогдох стандартын өөрчлөлттэй нийцүүлэн шинэчлэн сайжруулаагүй байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хүний эрхийн Үндэсний Комиссын бэлтгэсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,348.7 сая төгрөгийн 2 хувь буюу 27.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	27.2	11.9	-15.3
Урьдчилгаа	70.8	25.1	-45.7
Бараа материал	51.2	71.9	20.7
Үндсэн хөрөнгө	96.2	87.4	-8.8
Нийт хөрөнгө	245.4	196.3	-49.1
Өр төлбөр	0.0	16.6	16.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	245.4	179.7	-65.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	245.4	196.3	-49.1

Авлага дансны үлдэгдэл 15.3 сая төгрөгөөр буурсан боловч тайлант онд цалин илүү тооцож олгосноос 11.9 сая төгрөгийн авлага үүссэн байна.

Тайлант онд 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Засгийн газрын 11-р байрны 5 давхрын 5мкв харанхуй өрөөг складын зориулалтаар түрээслэхээр болж жилийн төлбөрт 1.2 сая төгрөгийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газарт урьдчилж төлсөн. Мөн энэ зардлын ангилал дахь хэмнэгдсэн төсөв болох 23.8 сая төгрөгийг төвийн 2020 оны байрны түрээсийн төлбөрт урьдчилж шилжүүлснээс урьдчилгаа данс 25.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 16.6 төгрөгөөр өссөн нь ХХОАТ болон цалингийн өглөгийг барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 1,083.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,081.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, гүйцэтгэл 99.8 хувьтай, зарцуулаагүй үлдэгдэл 1.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилт: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд олон улсын байгууллагын хандив, тусламжаар 199.6 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 27.2 сая төгрөг төвлөрснөөс нийт 226.3 сая төгрөгийг зарцуулж, 0.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 6 эрсдэл тогтоож горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд санхүүгийн Acolous программ бүртгэлтэй байгаа боловч нягтлан бодох бүртгэл, тайлангаа цахимаар бэлтгээгүй нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, САГ-2020/19/СТА-ТЕЗ

байгууллагын удирдлагыг санхүүгийн мэдээллээр хурдан шуурхай хангах боломж дутмаг, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 16.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайланд анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Хүний эрхийн Үндэсний комисс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 94 мэдээллийг хугацаанд нь, 121 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайланд “Итгэл үзүүлсэн” тул 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйд дахин албан шаардлага хүргүүлсэн болно.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хүний эрхийн Үндэсний Комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өглөгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд 16.6 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.2-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийн төлөвлөлтийг бодитой хийх, өр төлбөр үүсгэхгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа НБББББ-ийг 2014 онд боловсруулж баталснаас хойш төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинэчлэн гаргасан журам болон холбогдох стандартын өөрчлөлттэй нийцүүлэн шинэчлэн сайжруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам,

зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, журам, заавар мөрдөгдөхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

НБББББ-ийг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлэн сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Шилэн данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 121 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны сайтад байршуулсан байна.

3.3.2 Эрсдэл:

Мэдээллийн ил тод байдал хангагдахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	149,250.6	108,972.8
33	АВЛАГА	27,195.6	11,946.6
34	УРЬДЧИЛГАА	70,843.9	25,089.4
35	БАРАА МАТЕРИАЛ	51,211.0	71,936.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	96,245.4	87,405.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	96,245.4	87,405.0
39200	Биет хөрөнгө	96,245.4	87,405.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	245,496.0	196,377.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	16,656.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	16,656.9
41300	Өглөг	0.0	16,656.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	245,496.0	179,721.0
51	Засгийн газрын хувь оролцоо	245,496.0	179,721.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	108,348.0	108,348.0
51200	Хуримтлагдсан үр дүн	128,247.8	62,472.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,900.2	8,900.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	245,496.0	196,377.9

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,577,247.5	1,282,979.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,577,247.5	1,282,979.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,498,418.8	1,348,754.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,498,418.8	1,348,754.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,452,667.1	1,309,420.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,042.8	672,484.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,912.0	82,029.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	48,333.6
2104	Хангамж, бараа материалын зардал	95,519.9	43,451.4
2107	Томилолт, зочны зардал	188,857.2	154,049.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,873.1	95,346.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,128.6	213,726.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,751.6	39,333.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	78,828.7	-65,775.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	78,828.7	-65,775.0

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,594,027.5	1,310,175.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,594,027.5	1,310,175.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,593,566.8	1,310,175.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,593,566.8	1,310,175.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,619.5	1,270,841.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,042.8	655,872.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,881.0	81,984.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	48,333.6
2104	Хангамж, бараа материалын зардал	95,910.7	44,135.9
2107	Томилолт, зочны зардал	188,857.2	169,496.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,717.0	49,592.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	407,877.3	221,427.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,947.3	39,333.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	460.7	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	460.7	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	460.7	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	460.7	0.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-460.7	0.0

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	166,667.3	0.0	166,667.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	166,667.3	0.0	166,667.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	78,828.7	0.0	78,828.7
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,496.0	0.0	245,496.0
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,496.0	0.0	245,496.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,496.0	0.0	245,496.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-65,775.0	0.0	-65,775.0
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179,721.0	0.0	179,721.0

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,083,344.6	1,081,422.3	1,922.3	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,083,344.6	1,081,422.3	1,922.3	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,046,337.6	1,044,513.9	1,823.7	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	655,872.1	655,872.1	0.0	100.0
210101	Үндсэн цалин	486,248.0	655,872.1	-169,624.1	134.9
210102	Нэмэгдэл	129,146.0	-	129,146.0	0.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,478.1	-	40,478.1	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,984.2	81,984.2	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	55,749.2	55,749.2	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,558.8	6,558.8	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,247.0	5,247.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,311.8	1,311.8	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,117.4	13,117.4	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,333.6	48,333.6	-	100.0
210304	Байрны түрээс	48,333.6	48,333.6	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	44,136.1	44,135.9	0.2	100.0
210401	Бичиг хэрэг	12,793.4	4,464.9	8,328.5	34.9
210402	Тээвэр, шатахуун	12,311.0	16,284.0	- 3,973.0	132.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,031.7	17,293.9	1,737.8	90.9
210404	Ном, хэвлэл	-	3,159.8	- 3,159.8	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,933.2	- 2,933.2	
2107	Томилолт, зочны зардал	102,648.6	100,974.3	1,674.3	98.4
210701	Гадаад албан томилолт	-	26,159.8	- 26,159.8	
210702	Дотоод албан томилолт	102,648.6	51,681.5	50,967.1	50.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	23,132.9	- 23,132.9	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,613.0	49,592.0	21.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,360.0	45,360.0	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198.0	177.0	21.0	89.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,055.0	4,055.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,750.0	63,621.8	128.2	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	63,750.0	63,621.8	128.2	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,007.0	36,908.4	98.6	99.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,600.0	20,540.0	60.0	99.7
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	20,600.0	20,540.0	60.0	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,407.0	16,368.4	38.6	99.8

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,407.0	16,368.4	38.6	99.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,083,344.6	1,081,422.3	1,922.3	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,083,344.6	1,081,422.3	1,922.3	99.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,083,344.6	1,081,422.3	1,922.3	99.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	99	99	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	49	49	-	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49	49	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	42	42	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	-	100.0

4.1 Нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	226,830,392.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	226,830,392.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	226,327,342.6
2107	Томилолт, зочны зардал	68,522,101.0
210702	Дотоод албан томилолт	68,522,101.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,805,241.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	157,805,241.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	503,050.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	503,050.0
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	503,050.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	226,830,392.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	226,830,392.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	226,830,392.6

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.04.25	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/19/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2019 оны санхүүгийн тайлангийн аудит			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тайлант онд харьяа татварын хэлтэст 16.6 сая төгрөгийн ХХОАТ-ын өглөгийн үлдэгдэлтэй.	16.6	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Нармандах
2	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа НБББББ-ийг 2014 онд боловсруулж баталснаас хойш төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинэчлэн гаргасан журам болон холбогдох стандартын өөрчлөлттэй нийцүүлэн шинэчлэн сайжруулаагүй.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Нармандах
3	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 121 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	С.Нармандах
4	Үндсэн хөрөнгөнд санхүүгийн Acolous программ бүртгэлтэй байгаа боловч нягтлан бодох бүртгэл, тайлангаа цахимаар бэлтгээгүй.	-	Албан шаардлага	Ерөнхий нягтлан бодогч	С.Нармандах
Нийт дүн		16.6			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 04 дугаар сарын 23 № 01/211
СЯГ-2020/19/СТА-ТЭЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:




Үндсэн хөрөнгөнд санхүүгийн Acolous программ бүртгэлтэй байгаа боловч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг программаар бэлтгээгүй нь бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдах, байгууллагын удирдлагыг санхүүгийн мэдээллээр хурдан шуурхай хангах боломж дутмаг, санхүүгийн тайлан архивлагдахгүй өгөгдлийн сангүй болох зэрэг эрсдэлтэй байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг арилгах, холбогдох арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, комиссын гишүүн П.Оюунчимэгт, Ерөнхий нягтлан бодогч С.Нармандах нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
 АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ
 АУДИТОР  Г.МӨНХЧИМЭГ
 АУДИТОР  Ч.ДАШДАВАА

ЗӨВШӨӨРСӨН:
 ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
 КОМИССЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, КОМИССЫН
 ГИШҮҮН  П.ОЮУНЧИМЭГ
 ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
 С.НАРМАНДАХ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

